


Тоон гарын үсгийн гэрчилгээгээний хугацаа дуссан бол доорх зааврыг даган шинэчлэн авна уу.

НЭВТРЭХ

1. www.monpass.mn вэб сайт-д байгууллагынхаа мэдээллээр нэвтэрнэ.



- Нууц үгээ мартсан бол [Нэвтрэх](#) цонхон дээр байгаа [Нууц үг сэргээх](#) линк дээр дарж бүртгэлтэй и-мэйл хаягаараа нууц үгээ шинээр авах боломжтой
- Нэвтрэх нэрээ мартсан бол 1800 2535 дугаараар лавлан авна уу.

ЗАХИАЛГА ХИЙХ

2. Нэвтэрч орсны дараа **Миний захиалгууд** хэсэг рүү орон **Шинэ захиалга үүсгэх** товч дээр дарна уу.

Хувийн мэдээлэл

- КОМПАНИ МЭДЭЭЛЭЛ
- МИНИЙ ЗАХИАЛГУУД**
- ОЛГОГДСОН ТООН ГАРЫН ҮСГҮҮД
- СУНГАХ ХҮСЭЛТҮҮД
- НЭХЭМЖЛЭХҮҮД
- ХҮЧИНГҮЙ ГЭРЧИЛГЭЭ
- ТУСЛАМЖ

Тоон гарын үсгийн захиалга

Шинэ захиалга үүсгэх | Итгэмжлэлийн маягт

Гэрээ | Албан бичиг

- Эзэмшигчийн мэдээлэл хэсэг дээр тоон гарын үсгийн гэрчилгээ шинэчлэх албан тушаалтны иргэний үнэмлэхийн мэдээлэл оруулна уу

ЭЗЭМШИГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

* Ургийн овог: Боржигон

* Эцэг/Эхийн нэр: Батаа

* Өөрийн нэр: Дорж

Гадаад иргэн эсэх:

* Регистрийн дугаар: 0045121401

* Хүйс: Эр Эм

- Байгууллагын мэдээлэл хэсэг дээр Албан тушаал ба Салбар/Хэлтэс хэсгийг бөглөнө үү

БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ

* Компани нэр: А ХХК

* Албан тушаал: Захирал

* Салбар / Хэлтэс: Захиргаа

- Тоон гарын үсгийн мэдээлэл хэсэг дээр тухайн албан тушаалтан дээр хэдэн жилийн тоон гарын үсгийн гэрчилгээ авахыг сонгоно уу. /1 жил, 2 жил/
- **ТЭЭГЧ ТӨХӨӨРӨМЖ e-TOKEN БАЙГАА БОЛ ҮГҮЙ ГЭЖ ДАРАХЫГ АНХААРНА УУ!**

ТООН ГАРЫН ҮСГИЙН МЭДЭЭЛЭЛ				
1	Ажилтаны тоон гарын үсгийн гэрчилгээ /Class-3/ 2 жил	<input type="radio"/> 1 жил	<input checked="" type="radio"/> 2 жил	40,000.00
2	Тоон гарын үсгийн тээгч төхөөрөмж (eToken storage)	<input type="radio"/> Тийм	<input checked="" type="radio"/> Үгүй	0.00
			Бараа ажил үйлчилгээний үнэ:	40,000.00
			НӨАТ:	4,000.00
			Нийт дүн:	44,000.00

- Нэмэлт мэдээлэл хэсэг дээр тухайн албан тушаалтны мэйл хаягийг ямар нэгэн үг үсэгний алдаагүй оруулна уу (тухайн мэйл хаяг руу **баталгаажуулах линк** илгээгддэг учир) Би гэрээний нөхцлийг зөвшөөрч байна цонх чэклээд **Хадгалах** товч дээр дарна уу

НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

* И-мэйл хаяг:

Хоёр дахь и-мэйл хаяг:

Холбоо барих утас:

Тайлбар

өмнөөс итгэмжлэл үйлдэж, байгууллагын тамга, тэмдэг дарж, нотариатаар батлуулсан байна.

3.2 ГББ-ын ажилтан ирсэн хүсэлтийг баримт бичгийн дагуу нягтлан шалгаад, гэрээнд гарын үсэг зурж, тэмдэг дарснаар гэрээ байгуулагдана. БН-ийн ажилтан E-Token төхөөрөмжид хос түлхүүр болон ГОХ-ийг үүсгэж, нийтийн түлхүүрийн хамт ГОБ-руу илгээснээр Тоон гарын үсгийн гэрчилгээ үүсгэгдэнэ. Үүсгэсэн гэрчилгээг Эзэмшигч "Monpass Client" хэрэглэгчийн програм ашиглан татан авч E-Token төхөөрөмжид бичнэ /гэрчилгээг татаж суулгах зааврыг "Monpass Client" програмын заавраас харна уу/. Гэрчилгээг анх үүсгэсэн огноогоор гэрчилгээний хүчинтэй хугацаа эхэлж, гэрчилгээнд заасан дуусах хугацаа хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ. Тоон гарын үсгийн гэрчилгээг нэгээс хоёр жилийн хугацаагаар олгоно.

ДӨРӨВ. ТГҮГ-Г ШИНЭЧЛЭН АВАХ


4.1 ТГҮГ-ний хугацаа дуусахаас 1 сараас доошгүй хугацааны өмнө гэрчилгээгээ шинэчлэн авах хүсэлтийг Эзэмшигчийн ажилладаг ААН-ийн удирдлагын тоон гарын үсэг зурсан цахим албан бичиг дээр үндэслэн гаргана. ТГҮГ шинэчлэн авах өргөдлийн хүсэлтийг ГОБ-ын www.monpass.mn/extension веб хаягаар хандаж онлайн-аар гаргана.

4.2 ТГҮГ-ийн шинэчлэлт...

Би гэрээний нөхцөлийг зөвшөөрч байна

ЗАХИАЛГАА БАТАЛГААЖУУЛАХ

- Захиалгаа хадгалсны дараа та Нэмэлт мэдээлэл дээр **хамгийн эхэнд хийсэн мэйл хаягаа** шалган баталгаажуулах линк болох “Энд дар” дээр дарж хийсэн захиалгаа баталгаажуулна уу.
- Захиалгаа баталгаажуулаагүй тохиолдолд төлбөрийн баримт гарах боломжгүй тул та заавал захиалгаа баталгаажуулна уу!



МОНПАСС СА
to me ▾

ᠮᠣᠩᠯᠠᠮᠤ Mongolian ▾ > English ▾ [Translate message](#)


Таньд энэ өдрийн мэндийг хүргэе!

Таны тоон гарын үсгийн гэрчилгээ авах хүсэлт “Монпасс СА” ТГҮГ олгох байгууллагад ирсэн байна. Та дараах мэдээллийг шалгаж хүсэлтийг баталгаажуулах линк дээр дарж баталгаажуулна уу!


Байгууллагын нэр: А ХХК
Албан тушаал: Захирал
Эцэг/эхийн нэр: Батаа
Өөрийн нэр: Дорж
Регистрийн дугаар: ӨӨ45121401
Холбоо барих утас:
Шинээр Э-токен төхөөрөмж авах: Үгүй<
Баталгаажуулах линк: [Энд дар](#)

НЭХЭМЖЛЭХ ҮҮСГЭЖ ТӨЛБӨРӨӨ ХИЙХ

4. Захиалгаа баталгаажуулсны дараа Нэхэмжлэхүүд хэсэг рүү орон Нэхэмжлэх үүсгэх товч дээр дарна уу.




- Гарч ирсэн нэхэмжлэхийн хуудасны доод талд ХАДГАЛАХ товч дээр дарж нэхэмжлэхээ үүсгэнэ үү.



- Нэхэмжлэхээ үүсгэсний дараа Нэхэмжлэхийн дугаар болох 12 оронтой тоо гарч ирнэ. Төлбөрийн мэдээлэлээ харахын тулд тус 12 оронтой тоон дээр дарна уу.

Нэхэмжлэх №	Огноо	Нэхэмжилсэн	Төлөв	Үйлдэл	Устгах
156687830291	2019/08/27	44,000	Шинэ	Картаар төлөх Татах	Устгах
Нийт дүн:		44,000			

- Нэхэмжлэхийн хуудас дээрх мэдээлэлийн дагуу төлбөрөө тушаана уу



12 оронтой тоогоо гүйлгээний утга хэсэгт оруулах

НЭХЭМЖЛЭХ
156687830291

"Монпасс СА" УХК
РД: 6010709
Дансны дугаар: Голomt банк
2205110546

Утас/Факс: 976-76105286
info@monpass.mn
http://www.monpass.mn

Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 1-р хороо, Нисора цамхаг - 204 тоот

ТӨЛӨГЧ
А УХК
0000001
89810628
Монгол улс, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 7

Мөнгөн дүн төгрөгөөр				
№	Гүйлгээний утга	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Ажилтаны тоон гарын үсгийн гэрчилгээ /Class-3/ 2 жил	1	40,000.00	40,000.00
		Барaa ажил үйлчилгээний үнэ:		40,000
		НӨАТ:		4,000
		Нийт дүн:		44,000.00

Нэмэлт мэдээлэл:
Та тоон гарын үсгийн гэрчилгээ авахдаа дараах баримт бичгийг бүрдүүлэх шаардлагатай. Гэрээ, албан бичиг, нэхэмжлэх болон итгэмжлэхийн загварыг онлайнаар хүсэлтээ бөглөсний дараа гарч ирэх холбоосоор татаж авна.

Банкинд төлбөр төлөхдөө:
Төлбөр төлөх дансны дугаар: Голomt банк 2205110546. Хүлээн авагч: МОН ПАСС СА УХК. Банкны баримтын гүйлгээний утга талбарт зөвхөн Нэхэмжлэхийн дугаар болох 12 оронтой тоог бичнэ. Өөр ямар нэг мэдээлэл бичихгүйг анхаарна уу.

Бүртгэлийн байгууллагад очихдоо бүрдүүлэх ёстой баримт бичгүүд:

- Гэрээ 2% (хүсэлтээ бөглөсний дараа татан авч, хэвлэж гарын үсэг зурж, захирлаар батлуулна);
- Иргэний үнэмлэх, түүний хуулбар;
- Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар батлуулсан хуулбар;
- Байгууллагын албан бичиг (хүсэлтээ бөглөсний дараа татан авч, захирал гарын үсэг зурж, тамга дарсан байна);
- Итгэмжлэх (эзэмшигч өөрийн биеэр гэрчилгээг хүлээн авах боломжгүй үед өөрийгөө төлөөлөн гэрчилгээ авах хүнд олгоно. Итгэмжлэхийн маягыг <https://monpass.mn/support> хаягаас татаж авч, нотариатаар баталгаажуулсан байна);

Хаах

ОЛГОЛТЫН ТӨВ ДЭЭР ИРЖ ТООН ГАРЫН ҮСГЭЭ ШИНЭЧЛЭХ

5. Та төлбөрөө тушаасны дараа албан хүсэлтээ [энд](#) дарж татаж авна уу. Уг албан хүсэлтийг бөглөн удирдлагын гарын үсэг тамгаар баталгаажуулан өөрийн биеэр токентойгоо хамт Олголтын төв дээр ирэн тоон гарын үсгээ шинэчлэн авна уу.

Олголтын төвүүд	Хэн ирэх	Ямар бичиг баримт бүрдүүлэх
<ul style="list-style-type: none">Төв оффис: БЗД, 13 хороолол 18 хороо Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж 14/4 байр 4 давхарДүнжингарав Нийслэлийн нэг цэгийн үйлчилгээ 52 цонх	<ul style="list-style-type: none">Тоон гарын үсгийн эзэмшигч өөрийн биеэр ирнэ	<ul style="list-style-type: none">Албан хүсэлтУлсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарИргэний үнэмлэхийн хуулбарТокен төхөөрөмж

1. Эзэмшигч өөрийн биеэр гэрчилгээг хүлээн авах боломжгүй бол өөрийгөө төлөөлөн гэрчилгээ авах хүнд итгэмжлэл олгож болно.

Итгэмжлэлээр албан тушаалтны тоон гарын үсэг авч байгаа тохиолдолд бүрдүүлэх бичиг баримтууд:

- Албан хүсэлт
- Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
- Иргэний үнэмлэхийн хуулбар
- Токен төхөөрөмж
- Итгэмжлэл